



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” 2012 оны 05 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зэрчлэөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дэх заалтын “6 дугаар хавсралтаар” гэсний дараа “, “Баталгааны маягт”-ыг 7 дугаар хавсралтаар” гэж нэмсүгэй.


2.“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын “Мэдүүлэг гаргах, түүнийг бүртгэх, хадгалах” гэсэн Хоёр дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 2.6¹ дэх дэд заалт нэмсүгэй:

“2.6¹.Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим сан (<https://meduuleg.iaac.mn>)-д мэдүүлгээ гаргасан бол үнэн, зөв мэдүүлсэн талаарх баталгааг тухайн байгууллагын мэдүүлгийг хүлээн авах эрх бүхий албан тушаалтанд гаргана.”

3.“Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам батлах тухай” Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын “Нийтлэг үндэслэл” гэсэн Нэг дэх хэсгийн 1.2 дахь дэд заалтын “биечлэн болон” гэсний дараа “цахим хэлбэрээр” гэж, мөн хавсралтын “Мэдүүлгийг бүртгэж хүлээн авах байгууллага, эрх бүхий албан тушаалтны эрх, үүрэг” гэсэн Гурав дахь хэсгийн 3.4.2 дахь дэд заалтын “урьдчилсан мэдүүлэг , ” гэсний дараа “энэ журмын 2.6¹-д заасан баталгаа,” гэж тус тус нэмсүгэй.

4.“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай баталгааны маягт”, “Нийтийн албанд томилогдооор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай баталгааны маягт”, “Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнаас гаргах баталгааны маягт”-ыг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

5.Энэ тогтоолыг 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



БАТАЛГААНЫ МЯГТ

*/Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын
мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай/*

Дугаар ...

... он ... сар ... өдөр

/Байгууллагын нэр/

/Эцэг /эх/-ийн нэр, нэр/

/Салбар, нэгжийн нэр/

/Регистрийн дугаар/

/Албан тушаал/

/Албан тушаалд томилогдсон
огноо, шийдвэрийн дугаар/

(<https://meduuleg.iaac.mn/> цахим системд бүртгэгдсэн имэйл хаяг)

ХАСХОМ-ийг мэдүүлэх болсон үндэслэлийг сонгож тэмдэглэнэ үү.

- Томилогдсон, сонгогдоноос хойш 30 хоногийн дотор гаргасан
- Шинэчлэн гаргасан тайлант он
- Хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлт

ХАСХОМ-ийг мэдүүлэх эрхийг цахим системд үүсгэсэн огноо:

ХАСХОМ-ийн баталгааны маягтыг хүлээн авч,
цахим системд баталгаажуулсан огноо:

..... /эцэг /эх/-ийн нэр/ /нэр/ миний бие
Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 10.4 дэх хэсэг, Нийтийн
албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын
зэрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.3 дахь
хэсэгт заасны дагуу хуудас бүхий ХАСХОМ-ийг Авлигатай тэмцэх газрын
(<https://meduuleg.iaac.mn/>) цахим системд бүрэн гүйцэд, үнэн зөв мэдүүлснээ
баталж байна.

ХАСХОМ мэдүүлэхтэй холбоотой үүргээ зөрчвэл хуульд заасан хариуцлага
хүлээнэ.

Баталгаа гаргасан,
Мэдүүлэг гаргагч:

/Эцэг /эх/-ийн нэр, нэр/

/Гарын үсэг/

Баталгааны маягтыг хүлээж авсан,
Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах
эрх бүхий албан тушаалтан:

/Албан тушаал/

/Эцэг /эх/-ийн нэр, нэр/

/Гарын үсэг/

БАТАЛГААНЫ МАЯГТ

/Нийтийн албанад томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг
сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай/

Дугаар ...

... он ... сар ... өдөр

/Байгууллагын нэр/

/Эцэг /эх/-ийн нэр, нэр/

/Салбар, нэгжийн нэр/

/Регистрийн дугаар/

/Томилогдохоор нэр дэвшиж буй албан тушаал/

(<https://meduuleg.iaac.mn/> цахим системд бүртгэгдсэн имэйл хаяг)

ХАСУМ-ийг мэдүүлэх эрхийг цахим системд үүсгэсэн огноо:

ХАСУМ-ийн баталгааны маягтыг хүлээн авч,

Цахим системд баталгаажуулсан огноо:

Нийтийн албанад томилогдохоор нэр дэвшигч /эцэг /эх/-ийн нэр/ /нэр/ миний бие Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.5 дахь хэсэгт заасныг баримтлан хуудас бүхий ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газрын (<https://meduuleg.iaac.mn/>) цахим системд бүрэн гүйцэд, үнэн зөв мэдүүлснээ баталж байна.

ХАСУМ мэдүүлэхтэй холбоотой үүргээ зөрчвэл хуульд заасан хариуцлага хүлээнэ.

**Баталгаа гаргасан,
Мэдүүлэг гаргагч:**

/Эцэг /эх/-ийн нэр, нэр/

/Гарын үсэг/

**Баталгааны маягтыг хүлээж авсан,
Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах
эрх бүхий албан тушаалтан:**

/Албан тушаал/

/Эцэг /эх/-ийн нэр, нэр/

/Гарын үсэг/

БАТАЛГААНЫ МЯГТ
/Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий
албан тушаалтнаас гаргах/

... он ... сар ... өдөр

/Байгууллагын нэр/

/Эцэг /эх/-ийн нэр, нэр/

/Салбар, нэгжийн нэр/

/Регистрийн дугаар/

/Албан тушаал/

/ЭБАТ-аар томилогдсон огноо,
шийдвэрийн дугаар/

(<https://meduuleg.iaac.mn/> цахим системд ЭБАТ-аар бүртгэгдсэн имэйл хаяг)

**Эрх бүхий албан тушаалтны эрхийг цахим системд үүсгэсэн
огноо:**

Эрх бүхий албан тушаалтан /эцэг /эх/-ийн нэр/ /нэр/ миний бие Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуульд заасныг баримтлан өөрийн хариуцсан байгууллагын нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, мэдүүлэг гаргагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, тэдгээртэй холбоотой хувь хүний мэдээллийн нууцлалыг чанд хадгалж хамгаалан, задруулахгүй байх баталгаа гаргаж байна.

Миний бие албаны чиг үүргийн дагуу олж мэдсэн мэдээлэл, мэдүүлэг гаргагчийн мэдүүлэг, холбогдох баримт бичиг болон хувь хүний нууцыг бусдад задруулах, үзүүлэх, дамжуулах, үрэгдүүлэх, хууль бусаар ашиглах болон бусад байдлаар зэрчсэн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Баталгаа гаргасан,
Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах
эрх бүхий албан тушаалтан:

/Эцэг /эх/-ийн нэр, нэр/

/Гарын үсэг/

Баталгааны маягтыг хүлээж авсан,
Байгууллагын дарга, удирдлага

/Албан тушаал/

/Эцэг /эх/-ийн нэр, нэр/

/Гарын үсэг/